



СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№136 /350/

2022.08.04

Цаг үе, үйл явдал

ШИНЭ ТӨГСӨГЧИД ЦОЛ ГАРДАЖ, ТОМИЛОЛТОО ӨВӨРТӨЛЛӨӨ



ОХУ-ын Цэргийн академи, их дээд сургууль болон ҮБХИС-ийг 2022 онд төгссөн төгсөгчдөд цол гардуулах, Зэвсэгт хүчний Төрлийн цэргийн командлал, нэгтгэл, анги, байгууллагад томилох арга хэмжээ өчигдөр ЗХЖШ-ын жагсаалын талбайд зохион байгуулагдлаа.

Тус арга хэмжээнд ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг, ЗХЖШ-ын орлогч дарга хурандаа Т.Галбадрах болон Төрлийн цэргийн командлал, ЗХЖШ-ын газар хэлтсийн дарга нар болон холбогдох албан тушаалтнууд оролцлоо.

Арга хэмжээний эхэнд ОХУ-ын цэргийн их дээд сургууль төгссөн Ц.Тамир, Б.Сэнгээ, Б.Сумьяабазар нарын алба хаагчдад дэслэгч цол олгож улмаар нийт төгсөгчдөд томилолтын хуудсыг нь гардуулан өглөө. Энэ жилийн тухайд 300 гаруй офицер, ахлагч нар шинэ албан тушаал томилогдож буй юм.

Батлан хамгаалах салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагаа сүүлийн жилүүдэд эрчимтэй хөгжиж байгаа бөгөөд үүний нөлөөгөөр Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид гадаадын их, дээд сургуулиудад суралцан мэдлэг боловсролоо дээшлүүлсээр байна. Тухайлбал, ОХУ-д 1997 оноос хойш 450 гаруй офицеруудыг суралцуулсан гэх тоо баримт байна. Энэ нь Зэвсэгт хүчний хүний нөөцийн мэдлэг, ур чадвар улам бүр бэхжүүлж байна.

Ийнхүү Зэвсэгт хүчний удирдах бүрэлдэхүүнээсээ ажил амьдралынхаа анхны гараа болсон томилолтоо гардан авсан нийт алба хаагчдад хандан ЗХЖШ-ын дарга дэслэгч генерал Д.Ганзориг үүрэг чиглэл өгч ажил албандаа эзний ёсоор хандахыг захилаа.



АРАВТ"-Д ОРОЛЦОХООР ОХУ, УЗБЕКИСТАН УЛСЫН БАГУУД ИРЛЭЭ



"Аравт" олон улсын морин цэргийн уралдаан Монгол Улсад энэ сарын 13-19-ны өдрүүдэд зохион байгуулагдана.

Энэхүү олон улсын уралдаанд оролцохоор ОХУ, Узбекистан Улсын багууд өчигдөр хүрэлцэн ирлээ. Хоёр улсын баг тамирчдыг "Аравт" олон улсын морин цэргийн уралдаан зохион байгуулах хорооны дарга, ерөнхий шүүгч, ЗХЖШ-ын Сургалт бэлтгэлийн газрын Биеийн тамир, спортын тасгийн дарга, Монгол Улсын гавьяат дасгалжуулагч, хурандаа Д.Цог-Эрдэнэ "Буянт ухаа" олон улсын нисэх буудлаас угтан авсан юм.

Тэрээр хоёр орны цэргийн алба хаагчдад "Та бүхэн манай сайхан оронд тавтай морил. Анх удаагаа Монгол Улсад зохион байгуулагдах гэж байгаа олон улсын уралдаанд оролцохоор хүрэлцэн ирсэнд ЗХЖШ-ын даргын нэрийн өмнөөс талархал илэрхийлье" гээд уралдаандаа амжилт үзүүлэхийг хүслээ.

Үргэлжлэл нь II нүүрт!

ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 25	🌧️ 11


ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
☀️ 31	🌧️ 22

ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD 🇺🇸	3.203.00	3.210.0
EUR 🇪🇺	3.271.0	3.290.0
CNY 🇨🇳	473.00	475.00
RUB 🇷🇺	50.30	51.00
JPY 🇯🇵	23.70	24.15
KRW 🇰🇷	2.41	2.43

ЗУРХАЙ



2022.08.04 /ПҮРЭВ ГАРАГ/ БИЛГИЙН ТООЛЛЫН 7

ЗУНЫ АДАГ УЛААГЧИН ХОНЬ САРЫН ГУРВАН ХӨХ МЭНГЭТЭЙ ШАРАГЧИН ҮХЭР ӨДӨР

Үс засуулбал:

Хэл ам, хэрүүл тэмцэл ирнэ

НАРАН УРГАХ, ШИНГЭХ:

05.32-20.24

БАРИЛДАГА:

Хотол чуулган

ШҮТЭН БАРИЛДАГА:

Мунхрахуй

Суудал: Уул

Энэ өдөр тахиа, могой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба үхэр, луу, хонь, нохойжилтнээсөргөмүүлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр найз нөхдийг түшиж элдэв үйлийг түргэн бүтээх, бүтээл туурвил эхлэх, бизнес эхлэх, цар ихтэй үйлийг эхлэх, бясалгал хийх, доодсыг асран өглөг, хандив өргөх, лус тахиx, мал арилжих, буг дарах, газрын ам бооход сайн. Цөөрөм байгуулах, байшингийн суурь тавих, угаал үйлдэхэд муу.

Өдрийн сайн цаг нь бар, туулай, могой, бич, нохой, гахай болой. Хол газар яваар одогсод баруун хойд зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.

КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 585,143,027

Эдгэрсэн

Нийт: 555,732,233

Нас барсан

Нийт: 6,426,600

АРАВТ"-Д ОРОЛЦОХООР ОХУ, УЗБЕКИСТАН УЛСЫН БАГУУД ИРЛЭЭ



Түрүүч нь I нүүрт/ Үүний дараа хоёр орны баг тамирчдыг Зэвсэгт хүчний Сургалтын нэгдсэн төвд "Аравт" олон улсын морин цэргийн уралдаан зохион байгуулах хорооны штабын дарга, Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн захирагч хурандаа Ш.Гантулга тэргүүтэй удирдлагууд хүлээн авлаа. Энэ жилийн "Аравт" олон улсын морин цэргийн уралдаанд Монгол Улс, ОХУ, Узбекистан, Зимбабве зэрэг орнуудын морьтон дайчид оролцоно. Уралдаанд оролцож буй тамирчид тэмцээн эхлэхээс өмнө морьтой дадлага сургалт хийж, соёл урлаг, спортоор "өрсөлдөж", Монгол Улсын зан заншил, түүх уламжлал, адууны өв соёлтой танилцах юм.
4 дэх улс болох Зимбабве улсын баг тамирчид энэ сарын 6-ны өдөр хүрэлцэн ирнэ.



НИЙТ ТӨГСӨГЧДӨД МОНГОЛ УЛСЫН ЗЭВСЭГТ ХҮЧИН, ТӨРЛИЙН ЦЭРГИЙН КОМАНДЛАЛЫН ТАЛААР ТАНИЛЦУУЛЛАА



ҮБХИС болон ОХУ-ын цэргийн академи, их дээд сургуулийг 2022 онд төгссөн төгсөгчдөд Монгол Улсын Зэвсэгт хүчин, Төрлийн цэргийн командлалын үйл ажиллагааны талаар танилцуулах өдөрлөгийг өчигдөр анх удаа зохион байгууллаа.

Тус өдөрлөгт Зэвсэгт хүчний үйл ажиллагааны талаар ЗХЖШ-ын БСТГ-ын Цэргийн бодлогын хэлтсийн цэргийн бодлогын мэргэжилтэн дэд хурандаа Л.Давааням, Хуурай замын цэргийн үйл ажиллагааны талаар Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн командлалын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга хурандаа С.Жаргалсайхан, Агаарын цэргийн үйл ажиллагааны талаар Зэвсэгт хүчний Агаарын цэргийн

командлалын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн хурандаа Ч.Буянзаяа, Тусгай хүчний цэргийн үйл ажиллагааны талаар Зэвсэгт хүчний Тусгай хүчний цэргийн командлалын Сургалтын хэлтсийн дарга дэд хурандаа Л.Баясгалан, Кибер аюулгүй байдлын цэргийн үйл ажиллагааны талаар Зэвсэгт хүчний Кибер аюулгүй байдлын цэргийн командлалын Судалгаа, үйлдвэрлэлийн төвийн дарга ахмад Б.Болдхүү, Барилга-инженерийн цэргийн үйл ажиллагааны талаар Зэвсэгт хүчний Барилга-инженерийн цэргийн удирдах газрын Захиргааны удирдлагын хэлтсийн дарга дэд хурандаа Б.Балжинням нар танилцууллаа.

Энэ үеэр ЗХЖШ-ын Сургалтын бэлтгэлийн

газрын дарга бригадын генерал Г.Болор "Өнөөдөр /08.03/ Монгол Улсын Батлан хамгаалах салбарт нэгэн баярт өдөр тохиож байна. Учир нь Зэвсэгт хүчний ирээдүйг түүчээлэх шинэхан боловсон хүчнээ өнөөдөр угтан авлаа. Жил болгон уламжлал болгон зохион байгуулагддаг тус үйл ажиллагааны энэ жилийн онцлог нь ЗХЖШ-ын даргын зүгээс нийт төгсөгчдөд хандан өөрийнхөө захиас сургамжийг хэлж, офицерын эгнээнд элсэж буй залууст цолыг нь гардуулан өгөхөөс гадна Зэвсэгт хүчний үйл ажиллагааг танилцуулах өдөрлөгийг зохион байгууллаа. Энэ нь сургуулиа шинээр төгсөж буй офицер, ахлагч нарт анхны сэтгэгдлийг төрүүлэх, ажлынхаа гарааг хаанаас эхлэх вэ гэдгийг мэдэх чухал ач холбогдолтой юм" гэлээ.

Цахим шууданд

8 АЙЛЫН ОРОН СУУЦ АШИГЛАЛТАД ОРЛОО

Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн 305 дугаар тусгай салбарт Зэвсэгт хүчний Хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдсан албан тушаалын 8 айлын орон сууцыг ашиглалтад оруулав.

Тус байр ашиглалтад орсноор офицер, ахлагч нарын амьдрах ая тухтай орчныг бүрдүүлж, БХЯ, ЗХЖШ, Агаарын цэргийн командлалын удирдлагаас алслагдсан орон нутгийн анги, салбарт томилогдон ажиллаж байгаа алба хаагчдын нийгмийн хамгаалалд анхаарал хандуулж байдгийн том илэрхийлэл болж байна.



МЭДЭЭЛЛИЙН БУЛАНГАА ШИНЭЧЛЭВ



Зэвсэгт хүчний 013 дугаар анги

Ротын 7 хонгийн мэдээллийн буланд тавигдаж байдаг танин мэдэхүйн буланг шинэчиллээ.

Энэхүү мэдээллийн булангийн гол зорилго нь хугацаат цэргийн алба хаагчдыг цэрэгт татагдан ирсэн цагаас эхлэн тэдэнд эх оронч хүмүүжил олгохоос гадна хувь хүний хөгжил, хөгжлийн зорилго, ач холбогдол, оюун санааны хөгжил, одоо ба ирээдүйн тухай шинэ мэдлэг эзэмшүүлэх зорилготойгоор мэдээллийн булан бүрд

тодорхой кэйсүүдтэйгээр нийтэлдэг юм.

Түүнчлэн онцлох булангууд нь эх орон, дэлхий дахинд, тархи цэнэглэгч, эрүүл мэнд, өөрийгөө хөгжүүлэх, хууль, сонирхолтой мэдээлэл, англи хэл, суутнуудын хэлсэн сургаал үгс зэрэг гэх мэт булангууд багтсан юм. Шинэ дугаар бүрд дэс дараатайгаар өөрийгөө хөгжүүлэх булангуудыг оруулахаар төлөвлөж байна. Эдгээр мэдээллийн булангууд нь хэдий хугацаат цэргийн алба хаагчдад зориулсан боловч ангийн бусад бие бүрэлдэхүүн

бас уншиж мэдээлэл авах боломжтой юм.

Цаашид мэдээллийн булангаа сонирхолтой идэвхтэн уншигчтай болгох үүднээс тухайн дугаараасаа шалтгаалан шагналт уралдаан болзолтойгоор оруулж өгчээ.

Ахлах ахлагч Н.УУГАНЦЭЦЭГ

